

АМЬДРАЛ ГЭГЧ ИХ ШАТРЫН БОДЛОГО БОДОГЧ

Захиргаадалтын үед мэдээ, мэдээлэл тодорхой хэлбэл тооны ая холбогдол онцгой өндөр байлаа. Аймгийн удирдлага бараг өдөр бүр уулзаж төлөвлөгөөт ажлын биелэлтийн явцын тоо, дүгнэлт асууж удирдлагадаа хэрэглэнэ.

Статистикийнхан бид ч цоо шинэ мэдээ судалгаатай байхын тулд хариуцлагатай ажиллана. Ийн ярьж суугаа Данжингийн Аюуш бол тус аймгийн төлөвлөгөө, статистикийн байгууллагад 28 дахь жилдээ ажиллаж яваа байгууллагынхаа амьд цадиг намтар болсон хүн юм.

1941 онд Завхан аймгийн Ургамал сумын нутагт малчин айлын 14 хүхдийн гуравдугаарт төрсөн энэ шар хүү багадаа малд нүдтэй, өсөхдөө тоонд толгойтой болжээ.

Засагт хан аймгийн Сартуул хүн бүлгээ ажилд яамбай эцэг Данжин нь аймаг, сумын аварга малчин цол хүртэтлээ юу эсийг хийж, юу эсийг бодох билээ. Эх Цэрэндуламынх нь хийсэн дээл, хантааз, гутал тэргүүтнийг ус нутгийнхан нь гайхан магтаж "Уран" нэрийг хайрлажээ. Эцэг эх хоёр нь "Энэ хүү нэлээд нямбай няхуур болох өнгөтэй. Бид хоёрын юм хийж байхад дандаа ажиглаж байх юм, сургуулийн мөр хөөлгөөд үзье" гэж зөвлөж суусны нь бяцхан хүү яахин мэдэх. Хүүхдүүдээ ажил амьдралын дөртэй болгож залж зурахдаа Аюуш хүүдээ эцэг нь шатар заасан нь бодох сэтгэх ухааны нь задлаж өгөх гэсэн хэрэг байлаа. Шатрын бодлого нь арифметик цаашлаад дээд тоонд түүнийг залж эдийн засгийн дээд сургуулийн оюутан Аюуш шатрын II зэрэгтэй болж монголын шатрын томцуултай өрөг хайнцаж суулаа. Юм гэдэг хугацаатай болохоор оюутан цаг төгсөж аав, ээж, ах, дүү нарын өргөсөн алд цагаан хадаг, аяга дүүрэн сүү, аравт, зуутын дэвсгэртийг сайхан билгийн ерөөлийн хамт хүлээн авч, алжаалсан биеийн чилээ гаргаж хэд хоног амраад Ургамал сумынхаа унаган нутаг Шавгийн овоо, Хүнгүйн гол, Их бага Хатавчийн уул, хангайд тахил дээжээ өргүүлэн Төв аймгийн зүг хүлгийн жолоо залсан нь 1964 он, Одоогийн Өндөрширээт, Эрдэнэсантыг хамран хариуцаж Лүн сум дахь мэргэжилтний группэд эдийн засагчаар томилогдоод хөдөөд амьдрах болчихсон маань амьдралын минь алтан шар замын эхлэл юм шүү гээд тэр инээмсэглэв.

Тэгэвч бас хөдөөшиж амжсангүй Төв аймгийн ХЗЭ-ийн хорооны үйлдвэр ХАА-н хэлтсийн эхрлэгч гэсэн албанд нэг жагхийж аваад 1966 оны IX сард аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны статистикийн товчоонд анхан шатны бүртгэл, соёл боловсрол, хүн ам, иргэний гэр бүлийн тоо бүртгэл хариуцаад суух нь тэр. Яриаг нь чагнахад сэтгэлийнх нь гүнд ажил амьдралынх нь эхний мөр, анхны хайр дурлал, хурим найр, төрүүлж өсгөсөн хүүхдүүд нь үзэгдэх мэтээ.

Намайг анх статистикч болоход хортой цаас тав зургааг давхарлаад дарга нарын гарт үйлдсэн мэдээгээ хүргэнэ дээ. Хатуу балтай хорын харандаа тун чухалсан. Тоогоо голдуу сампиндана. Ганц нэг арфемометр гэж гараар эргүүлдэг машин ирж байсан цаг.

Аймагт статистик бүртгэлийн 100 гаруй нэрийн шуурхай болон улирал жилийн мэдээ тайлан гарна. Төлөвлөгөөний биелэлтээр сумд, байгууллага үйлдвэрүүдийг байр эзлүүлж эхний хэдийг улаанаар, сүүлчийнхийг хөхө өнгөөр ялгаж бичдэгсэн. Гол гол мэдээг том цааснаа үйлдэж хананд байрлуулна. Тэгэхдээ гүйцэтгэлийн сайн муугаар нь пуужин, онгоц, машин, морь, мэлхийд байрлуулна. Мэлхийд суусан дарга нар хариуцлага тооцуулж товчоо захиргааны хурлаар хөлслүүлээд гарна. Түрүүлсэн нь шагнуулна. Мэдээ мэдээллийн ач холбогдол ийм их. Чухал мэдээнүүд бидний гаргаснаар аймгийн сонинд тавигдана. Сумд мэдээгээ үнэн зөв гаргаж байна уу үгүй юу гэдгийг ч бид очиж шалгана. Бүүр нуруулдсан өвсийг нь хэмжиж байгаад, малыг нь тоолж үзнэ шүү дээ. Худал мэдээлбэл банга хүртэнэ.

Аюуш гуай статистикийн ийм л үнэнч зүтгэлтэй ажилтан анхандаа шатрын бодлогод хорхойсч суусан бол сүүлдээ амьдрал хэмээх их шатрын нүүдлийн бодлогод ухаан сийлж иржээ. Угаас ажигч, нямбай, хянуур тэвчээртэй зан чанар нь нөлөөлж тоо бүрийн утга учрыг нягтлан бодож задлан шинжилж, нэгтгэн дүгнэж тооцоо судалгаа гарган, төсөл, төлөвлөгөө зохиоход хэрэглэх үлгэрчилсэн норм, нормотивийн үндэслэл гаргах, сум үйлдвэрийн газруудын тайлан балансад шинжилгээ хийж дүгнэлт гаргах, таван жилийн төлөвлөгөө программын төсөл зохиоход оролцох гээд л хоёр нарны хоорондоос үл барам шөнө дөл болтол тоотой хүснэгт хурайлан нэгэн түмэн хоногийг ардаа үджээ.

Ер нь амьдрал гэдэг шатар нүүхтэй адил.

Хөгжил хөдөлгөөн нь ерөнхий нэгэн хуулиар уртын урт нүүдэл мэт хөврөх атлаа замд нь уул даваа гол ус, ган гачиг юу эс тохиолдохсон билээ. Тэр бүхний учрыг олж судлах нь ямарч нийгэмд зайлшгүй хийгдэх зүйл. Амьдрал хөгжил хөдөлгөөний тоон утгын лугших судсыг эдийн засагчид, бүртгэл зүйчид нарийвчлан магадлаж чадах билээ.

Нийгэм шинэ төрх төлөвт шилжих үеэр төлөвлөгөө, тоо бүртгэл хэрэггүй юм шиг үзэх, ойшоохгүй хүмүүс олширсон тал ч бий.

Гучаад жил тоо нухав. Эдийн засагч-статистикч энэ хүн таван таван жилд дундажаар 4600 гаруй мэдээ нэгтгэж, 400 гаруй мэдээ тайлан гарган төвд явуулж, аймгийн хөгжилд эдийн засагтай холбоотой өгүүлэл, мэдээ 20 орчмыг төв орон нутгийн хэвлэлд бичжээ.

1960-1994 он хүртэл 34 жилийн судалгаатай ийм эдийн засагч статистикч хир олон байдаг бол. Хүснэгт бөглөж Төв аймагчуудын ажил амьдралын тооны утгыг төр засаг хийгээд ард түмэнд үнэнээр нь илэрхийлж толилуулна гэдэг мэргэжлийн хүнд бахархалтай байхаас яахав. Мэргэжил ажил бүрийн өөр өөр онцлог бахархал бас бэрхшээл ч гэж бий.

Аюуш гуай таван хүүхэдтэй ам бүлээ энэ л мэргэжлийнхээ буянаар тэжээж, бүртгэл статистикийн тэргүүний ажилтан болж, энэ л ажлынхаа ачаар эх орныхоо хил алхан юм үзэж хөдөлмөрийн хүндэт медаль, ардын хувьсгалын 60,70 жилийн ойн хүндэт медаль, Засгийн газрын жуухаар шагнуулж явсан болохоор " ажлын үр дороо харагддаг, удирдлагын анхаарлыг эгзэгтэй ажил үйлдвэрлэлд нь төвлөрүүлдэг, хүмүүсийг хүссэн мэдээллээр хангаж явах" сайхан байдаг юм гэж бахархана.

Тэрээр аймгийн захиргааны хар бор ажил, биеийн хөдөлмөрт жил дараалан оролцож ирсэн хүн. 1967, 1973, 1986 оны их зудад малчны суурьт очиж айл нүүлгэх, цас арилгаж зам бэлчээр гаргах, хашаа хороо засварлах, дулаалах, хонь хариулах, төл бойжуулах, өвс хадлан бэлтгэх, барилга барилцах, зам талбайн ажилд 30-50 хоногоор халуунд халж, хүйтэнд хөрч явсныг алийг нь тоочих вэ.

Зах зээлийн нийгэмд мэдээллийн ач холбогдол бүүр ч их өснө. Аюуш гуайн туршлага ч залуу мэргэжилтнүүдэд гулзайхгүй түшиг болно доо.

(Ш.Цэрэндоогийн "Амьдрал шинжсэн тоочид" номоос)